



Хууль Зүйн Яам

Эрх Зүйн Мэдэгдэл

ТҮР ХОРИОНД ОРСОН 10-13 НАСНЫ ӨСВӨР ИРГЭНД ГАРДУУЛАХ

Доорх мэдээллүүдийг таны ойлгох хэл дээр бичиж танд өгсөн байх шаардлагатай.

Хэрвээ мэдээлэл нь таны ашиг сонирхолыг хөндөөгүй эсвэл шүүхийн үйл ажиллагаанд хор хөнөөлтэй биш бол таны эцэг эх, эсвэл хууль зүйн эрхтэй асран хүмүүжүүлэгч үүнтэй ижил мэдээлэл авна. Та энэ баримт бичгийг хоригдох хугацаанд хадгалж болно.

Таныг дор хаяж 5 жилийн ял шийтгэл эдлэх шийтгэлтэй хууль зөрчсөн гэмт хэрэг үйлдсэн гэх үл мөр байгаа учраас таныг түр хорионд хорих болсоныг танд мэдээлсэн.

Та өөрийн түр хоригдох болсон зөрчлийн үтгэ шинж, огноо ба байрлалыг мэдэх бүрэн эрхтэй болон түр хорих болсон тодорхой шалтгаануудыг мөн адил мэдэх эрхтэй.

Арван хоёр цагийн хугацаатай түр хорионы үеэр таны үйлдсэн зөрчлийн дагуу мөрдөн байцаалт хийнэ.

Энэ хугацааны эцэст Улсын прокурор (эсвэл анхан шатны шүүгч эсвэл хүүхдийн эрх хариуцсан шүүгч) таны түр хорих хугацааг дахин арван хоёр цагаар сунгах эсэхийг шийднэ. Энэ нь боломжгүй бол та шүүх хуралд оролцоно, үгүй бол видео шүүх хуралд оролцох болно. Хорих хугацааны эцэст та шүүх хуралд оролцоно эсвэл таныг суллана.

Та дор дурдсан эрхтэй:

Ойрын хүмүүст мэдээлэл хүргэх

Таны эцэг эхэд эсвэл таныг хариуцах асран хүмүүжүүлэгчид эсвэл танд үйлчлэх үйлчилгээнд таны үйлдсэн хэргийн тухай зайлшгүй мэдэгдэл хүргэнэ. Та хамт амьдардаг хүмүүст эсвэл эцэг эхийнхээ аль нэгэнд эсвэл ах эгчийн аль нэгэнд эсвэл өөрийнхөө куратор эсвэл өөрийн хүмүүжүүлэгчдээ түр хорионд орсон арга хэмжээний тухай утасдан мэдэгдэх боломжтой.

Хэрвээ та францын иргэн биш бол та өөрийн улсын консулын газарт мэдэгдэх эрхтэй.

Хэрвээ огт боломжгүй тохиолдлуудаас бусад тохиолдлуудад хүсэлт гаргаснаас 3 цагийн хугацаанд дээрх хүмүүст зайлшгүй мэдэгдэнэ.

Хэн нэгэнтэй холбоо барих

Та энэ хүмүүсийн аль нэгэнд бичгээр, утсаар эсвэл уулзах хүсэлт гаргаж болно.

Цагдаагийн ажилтан үүнийг аюултай гэж үзвэл хүсэлтээс татгалзаж болно. Тэр 30 минутаас илүүгүй хугацаатай үргэлжлэх энэхүү харилцаа хэзээ ба яаж болохыг тодорхойлно. Энэ харилцаа нь түүний хяналтан дор явагдана.

Эмчийн үзлэгт хамрах

Түр хорионы 12 цагийн дотор таныг эмчийн үзлэгт хамруулна.

Хэрвээ хориог сунгасан бол дахин давтан үзлэг хийнэ.

Мэдэгдэл хийх, асуултад хариулах эсвэл үг хэлэхгүй байх

Та өөрийгөө хэн болохыг мэдэгдсэний дараа шүүх хурлаар та доорх эрхийг эдэлнэ:

- мэдэгдэл гаргах,
- таниас асуусан асуултад хариулах,
- үг хэлэхгүй байх.

Хууль зүйн төлөөлөгчтэй хамт хүрэлцэн ирэх

Хэрвээ мэргэжлийн байгууллага зайлшгүй хэрэгцээтэй гэж үзвэл та шүүх хуралдаа таныг хариуцсан хүнтэй хамт хүрэлцэн ирнэ. Зарим тохиолдолд та өөр нэгэн насанд хүрсэн хүнийг хамтран хүрэлцэн оролцохоор тодорхойлж болно эсвэл шүүхээр тодорхойлсон хүн оролцож болно.

Өмгөөлөгчийн туслалцаа авах

Та заавал өмгөөлөгчийн туслалцаа авна.

Өмгөөлөгчийн сонголт

Түр хорио эхэлснээс эхлэн шүүх хурлын аливаа нэгэн мөч хүртэл түр хорих хугацаа сунгасан тохиолдолд сунгалтынхаа эхэнд та өмгөөлөгчийн туслалцаа нэхэх эрхтэй. Түүнийг таны эцэг эх эсвэл та өөрөө сонгож болно. Үгүй бол байгууллагаас өмгөөлөгч сонгоно.

Өмгөөлөгчийн туслалцаа ба оролцооны хугацаа

Өмгөөлөгч нь ярилцлагын нууцыг хадгалсан нөхцөл байдалд тантай 30 минутын хугацаанд ярилцах эрхтэй; хорих хугацааг сунгасан тохиолдолд та өөрийнхөө өмгөөлөгчтэй дахин уулзах хүсэлтийг давтан гаргаж болно.

Хэрвээ та хүсвэл, өмгөөлөгч таны байцаалтын үед таны хажууд байх болно.

Таны анхны шүүх хурал зөвхөн таны биеийн байцаалт дээр тулгуурлаж байгаа тохиолдлоос бусад тохиолдолд, таны өмгөөлөгчгүй 2 цагийн дотор ажиллагаагаа эхлэхгүй. Хоёр цаг өнгөрөхөд таны өмгөөлөгч ирэхгүй бол шүүх хурал эхэлж болно. Таны анхны шүүх хурал таны өмгөөлөгчийн эзгүйд ч гэсэн прокурорын зөвшөөрлөөр эсвэл анхан шатны шүүгчийн хүсэлтээр хэрвээ байцаалт нь үүнийг шаардаж байвал тэр дороо эхэлж болно.

Хэрвээ таны өмгөөлөгч шүүх хурлын үед ирвэл энэ хурлыг түүнийг тантай ярилцуулах зорилгоор хурлыг завсарлуулах болно.

Хэлмэрчийн туслалцаа авах

Хэрвээ та франц хэлээр ярьдаггүй ба ойлгодоггүй бол шүүх хурлуудынхаа үеэр болон өмгөөлөгчтэйгөө харилцах зорилгоор хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй.

Түр хориог дуусгах тухай хүсэлт гаргах

Та прокурорт эсвэл шүүгчид хандаж, хэрвээ шүүх энэхүү түр хорих хугацааг сунгах шийдвэр гаргасан тохиолдолд сунгахгүй байх хүсэлт гаргах эрхтэй.

Хэргийнхээ зарим хэсгүүдтэй танилцах

Таны өөрийн хүсэлтээр эсвэл таны өмгөөлөгчийн хүсэлтээр та өөрийн түр хориог сунгахын өмнө доорх байдлуудтай танилцах эрхтэй:

- таны түр хорих мэдэгдэлийн протокол,
- таныг үзсэн эмчийн гаргасан эрүүл мэндийн гэрчилгээ,
- таны шүүх хурлуудын протоколууд.

Прокурорт танилцуулга гаргах

Түр хорионы эцэст та дор хаяж нэг жилийн хугацаанд Улсын прокурорт баталгаатай захидлаар эсвэл нотариатын нотолгоотой итгэмжлэлээр өөрийн танилцуулгыг боловсруулах зорилгоор өөрийнхөө хэрэгтэй танилцах мэдэгдэл гаргаж болно

Хувийн нууцлалын эрх

Таны шүүх хурлуудад техникийн боломжгүй тохиолдлуудаас бусад үед видео бичлэг хийдэг.

Хэн ч энэ шүүх хурлын бичлэгүүдийг нийтэд гаргах эрхгүй. Энэ бичлэгүүдийг зөвхөн шүүх хурал хаалттай явагдаж багйаа үед гаргадаг.